



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.08.30 № ХЭГ/1586
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 3.1 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245016076



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**


Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 8. 30, № 1/558

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
Л.ГАНТӨМӨР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151603202
Doc. art 15.2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.08.30 № **01/7207**

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
Л.ГАНТӨМӨР ТАНАА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны
төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн
төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай
хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны
дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002278

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлд:

“3.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Засгийн газар байгуулагдаж, “Хурдтай Хөгжлийн Төлөөх Зориг” үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлж байна.

Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” Хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурлаар батлуулаад байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны төсвийн тодотголоор гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх дэд бүтцийн томоохон төслүүдийн санхүүжилтыг нэмэгдүүлснээс гадна бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан томоохон хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтийг тусгасан.

Харин ирэх 2025 оны төсвийн төсөлд энэхүү томоохон хөгжлийн төслүүдийн барилга, угсралтын ажлыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын санхүүжилтыг тусгаж байна. Ингэснээр эрчим хүчний салбарт либералчлалыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлнэ. Салбаруудын үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт, технологийн дэвшил, инновацыг дэмжих, тоног төхөөрөмжийн татвар, тарифыг хөнгөлөх бодлого хэрэгжүүлж, хөдөө аж ахуй, боловсруулах, уул уурхай гэх мэт салбаруудад эерэг нөлөө үзүүлнэ. Мөн хөрш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийн гадаад эрэлтийг тэлснээр аж үйлдвэр, боловсруулах салбарыг дэмжинэ. Түүнчлэн, гадаад жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд худалдаа, үйлчилгээний салбар болон бусад салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлнө.

Мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт орсон.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг зөв тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай эсхүл ашигтай байх” гэснийг “нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж, 6.1.3-т заасан “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;” гэснийг “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх”; гэж, Мөн өрийн удирдлагын тухай хуулийн 6.1.4 дах заалтын “өнөөгийн үнэ цэнээр” гэснийг “нэрлэсэн дүнгээр” гэж тус тус өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлтийн дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг дээрх төсвийн зарим тусгай шаардлагын өөрчлөлттэй нийцүүлэн боловсрууллаа.

Эдийн засгийн өсөлт 2025 онд эрчимжиж, 8.0 орчим хувьд хүрэх хүлээлттэй байна. Үүнд уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын экспорт нэмэгдэж, тээвэр логистик, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбарын үйл ажиллагаа идэвхжихээр байгаа нь голлон нөлөөлөхөөр байна. Цаашид, Оюутолгойн гүний уурхайн эрдсийн өндөр агуулгатай баяжмал үйлдвэрлэл болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэж, худалдааны түнш улс орнуудтай хийж буй худалдааны хэлэлцээрүүдийн хүрээнд хөрөнгө оруулалт, экспорт тогтвортой өссөнөөр 2026, 2027 онуудад эдийн засгийн өсөлт 6.5 хувь орчимд байхаар байна.

Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, өрхүүдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд инфляцыг бууруулж, 2025 онд 7.5 хувь, 2026 онд 5.0 хувь, 2027 онд 4.0 хувьд тус тус хүргэхээр хуулийн төсөлд тусгалаа. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг сайжруулах, экспорт, импорттой холбоотой зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг 10 тэрбум ам.долларт хүргэх, төсвийн алдагдлыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

- **Тэнцвэржүүлсэн орлого:** Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.
- **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ийн 2 хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2025-2027 онуудад 2 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2025 онд 55 хувь, 2026 онд 50 хувь, 2027 онд 45 хувьтай байхаар

тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан 2025 оны төсвийн жилээс эхлэн Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 60 хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2025 оны төсвийн зарлагын хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны зарлагын хязгаар төсөөлөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2024 он

АГУУЛГА

Нэг. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл	1
1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал	1
1.2. Макро эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	7
Хоёр. Макро эдийн засгийн 2025 оны чиг хандлага, төсөөлөл	8
2.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	8
2.2. Макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл.....	11
Гурав. Засгийн газраас 2025 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл.....	13
Дөрөв. Болзошгүй эрсдэлийн тойм	17

Зургийн жагсаалт

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлтийн бүрэлдэхүүнээр (хувь).....	1
Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)	2
Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь).....	3
Зураг 4. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь).....	3
Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн).....	4
Зураг 6. Ажиллах хүч (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	4
Зураг 7. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	4
Зураг 8. Гадаад валютын нөөц (сая ам.доллар).....	4
Зураг 9. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)	5
Зураг 10. Импортын өөрчлөлт (сая ам.доллар)	5
Зураг 11. Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар).....	6
Зураг 12. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (хувь)	8
Зураг 13. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	9
Зураг 14. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/трой унц)	9
Зураг 15. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)	10
Зураг 16. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	10
Зураг 17. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)	10

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь).....	1
--	---

Нэг. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл

1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал


Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний улиралд 16.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 6.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар тус тус өслөө¹. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр орууллаа.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024.I
ДНБ	-4.6	1.6	5.0	7.4	7.8
ХАА	0.8	-0.8	1.7	-1.3	-1.3
Үйлдвэрлэл	-1.3	-0.6	-1.2	3.2	2.8
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.9
Боловсруулах	0.3	-0.1	0.5	0.4	0.4
Цахилгаан, ус	0.0	0.2	0.1	0.1	0.3
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.2
Үйлчилгээ	-3.0	1.8	3.2	4.7	4.2
Худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Бусад	-0.6	1.5	1.7	2.1	2.2
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлтийн бүрэлдэхүүнээр (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 13 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.9 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд нүүрс олборлолт 22 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар, төмрийн хүдэр олборлолт 1.5 сая тонн болж 63.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв. Харин алт олборлолт 5.0 хувиар, газрын тос 10.0 хувиар тус тус буурч, зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оны түвшинд байлаа². Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр болон бараа, бүтээгдэхүүний импорт өссөнөөр ачаа тээвэр 2024 оны эхний улиралд 34.3 сая тоннд хүрч, тээврийн салбарын үйлдвэрлэл 27.0 хувиар тэлэв.

Амгалан ДЦС, Чойбалсан ДЦС, Яармаг-Нэгдүгээр хорооллыг холбох авто зам, гүүрэн байгууламж зэрэг томоохон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтууд 2024 оны эхний улиралд дуусах шатанд орсноор барилгын салбарын үйлдвэрлэл 27.7 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлэв. Түүнчлэн хүнсний үйлдвэрлэл тэр дундаа ундаа, спирт, усны үйлдвэрлэл нэмэгдэж,

¹ ҮСХ-ноос ДНБ-ий гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд зарладаг. ДНБ-ийг сар бүр тооцож бодлогын шийдвэрт дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮСХ-ноос туршилтын тооцоо хийж байна. Уг туршилтын тооцоогоор эдийн засаг 2024 оны эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өссөн байна.

² 2024 оны эхний хагас жилийн байдлаар нүүрс олборлолт 46 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 31 хувиар, төмрийн хүдэр, баяжмал олборлолт 4,599 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 47 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 735 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 4 хувиар тус тус өссөн байна. Харин алт олборлолт 5.3 тонн, газрын тос олборлолт 2.1 сая баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 18 болон 13 хувиар тус тус буураад байна.

боловсруулах салбар 6.3 хувиар өсөхөд голчлон нөлөөлөв. Харин өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсний улмаас мах боловсруулах үйлдвэрлэл 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 9 хувиар буураад байна.

Эрэлт талаас өсөлтийг эдийн засгийн дотоод идэвхжил дэмжиж байна. Засгийн газар тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлснээр төрийн хэрэглээ 2024 оны эхний улиралд 47.1 хувиар өслөө. Өрхийн бодит орлого³ 19.8 хувиар өссөнөөр өрхийн хэрэглээ төсөөллөөс давж 20.8 хувиар өсөв. Эдийн засгийн дотоод үйл ажиллагаа эрчимжин худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэж, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.5 хувиар өсөв. Өрхийн хүнсний бус хэрэглээ 30.6 хувиар нэмэгдсэнээр хүнсний бус бараа, бүтээгдэхүүний импорт 24.9 хувиар, хүнсний бус бүтээгдэхүүний дотоод худалдаа 19 хувиар өргөжин худалдааны салбарын нийт борлуулалтыг нэмэгдүүллээ. Түүнчлэн мэдээлэл, харилцаа холбооны салбар 26.3 хувиар, үйлчилгээний бусад салбарууд 3.7 хувиар өсөхөд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний улиралд 6.3 сая толгойд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгойгоор өндөр байв. Улмаар хөдөө аж ахуйн салбар 31.4 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар буурууллаа. Мөн том малын тоо толгой олноор хорогдсоны нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 5.4 хувиар буурсан байна.


Инфляц: Улсын жилийн инфляц 2024 оны 7 дугаар сард 5.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар буурлаа.

Инфляцын бууралтын 2.4 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 0.6 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.2 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, 0.2 нэгж хувийг эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, 0.2 нэгж хувийг зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, 0.6 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээ тус тус бүрдүүлсэн байна.

Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос эхлэн алгуур буурч тогтворжоод байна. Тухайлбал, импортын барааны үнэ 2024 оны 7 дугаар сард 4.1 хувиар өсөж, нийт инфляцын 1.9 нэгж хувь буюу 34.7 хувьтай тэнцэж байна. Худалдааны түнш орнуудын инфляц буурсан болон төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой хадгалагдсан нь импортын инфляц саарахад голлон нөлөөлөв.

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард 6.6 хувиар өсөж, нийт инфляцын 3.6 нэгж хувь буюу 65.3 хувийг бүрдүүллээ. Хүнсний барааны үнэ 2024 оны 7 дугаар сард 5.6 хувиар өссөн нь нийт инфляцын 1.7 нэгж хувийг бүрдүүлэв.

Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


³ ҮСХ өрхийн бодит орлогыг тооцоходоо өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогыг 2020 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлж тооцож байна.

Үүнээс дотоодын хүнсний үнийн өсөлт 1.6 нэгж хувийг бүрдүүлж, жилийн 5.5 хувийн өсөлттэй байлаа. Хүнсний үнийн өсөлтийн 85 хувийг талх, гурил, будаа, сүү, өндөг, хүнсний ногооны үнийн өсөлт бүрдүүлж байна. Харин мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх жилүүдтэй харьцуулахад багаар буюу өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өссөн байна.

Хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өсөж, нийт инфляцын 3.8 нэгж хувийг эзэлж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 6.1 хувиар, орон сууц, ус, цахилгаан болон түлшний бүлгийн үнэ 6.0 хувиар, эм тариа 5.6 хувиар өссөн нь нөлөөлжээ. Мөн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт саарч, жилийн 7.3 хувиар өссөн нь нийт инфляцын 1.6 нэгж хувийг бүрдүүлэв. Үйлчилгээний бүлгийн инфляцад боловсролын үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард 16.8 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 6 дугаар сарын байдлаар 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр талаас (пассив) төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт голлон нөлөөсөн буюу нийлбэр дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар өсөж, нийт өсөлтийн 27.2 нэгж хувийг бүрдүүлжээ. Харин мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт талаас (актив) авч үзвэл, гадаад цэвэр актив жилийн өсөлтийн 18.7 нэгж хувийг болон 13.2 нэгж хувийг дотоод цэвэр актив бүрдүүлж, голлох нөлөөг үзүүлэв.


Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)



Банкнаас гадуурх мөнгө
Хадгаламж, \$
Харилцах данс, \$
Харилцах данс, ₮
Хадгаламж, ₮
M2 мөнгө

Эх сурвалж: Монголбанк

Зураг 4. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь)



ЗГЦЗ
Бусад
ГЦА
Дотоод зээл
M2 мөнгө

Эх сурвалж: Монголбанк, тооцоолол

Тэмдэглэл: ЗГЦЗ- Засгийн газрын цэвэр зээл, ГЦА-Гадаад цэвэр актив


Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Хөдөлмөрийн зах зээл эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр сэргэж байна. Ажилчдын тоо 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 37.8 мянган хүнээр өсөж 1,294 мянга хүнд хүрсэн байна. Салбараар авч үзвэл худалдаа, үйлчилгээ, уул уурхай, тээвэр, цахилгааны салбарын ажилчид өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байгаа бол өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тоо буурсан байна.

Ажилчдын тоог хүйсээр харвал эхний улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 32 мянган хүнээр нэмэгдэж 702 мянгад хүрсэн бол эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 5.9 мянгаар өсөж 591 мянгад хүрлээ. Уул уурхай, тээвэр, боловсруулах салбарын идэвхжил бусад салбараас өндөр байсан нь эрэгтэй ажилчдын тоо эмэгтэй ажилчдаас өндрөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Зураг 6. Ажиллах хүч (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсөж 59.4 хувьд хүрлээ. Гэсэн хэдий ч цар тахлын өмнөх үеэс 1.2 нэгж хувиар бага байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өссөнөөр 56.3 хувьд хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 1.6 нэгж хувиар өндөр үзүүлэлттэй байна.

Төлбөрийн тэнцэл: Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 6 сард 57 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 тэрбум ам.доллороор нэмэгдсэн бол импортын өсөлт 1.2 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс 0.3 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Харин шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал нэмэгдэж, гадаад бонд болон худалдааны зээлийн эргэн төлөлттэй холбоотой гадаад валютын гарах урсгал буурснаар санхүүгийн дансны ашиг 0.7 тэрбум ам.долларт хүрч нэмэгдлээ. Засгийн газар 2024 оны 3 дугаар сард Хуралдай бондын үлдэгдэл төлбөрийг бүрэн төлж барагдуулаад байна. Гадаад валютын албан нөөц 2024 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбум ам.доллороор нэмэгдлээ.

Зураг 7. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 8. Гадаад валютын нөөц (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк, ЭЗХЯ-ны тооцоолол

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 6 сарын байдлаар 13.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар өссөн бол худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

2024 оны эхний 6 сарын байдлаар экспорт 7.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өслөө. Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор тус компанийн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ өссөн зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өссөн байна. БНХАУ-ын уурхайн хяналт шалгалтын улмаас тус улсын коксжих нүүрсний дотоод үйлдвэрлэл буурсан нь коксжих нүүрсний эрэлтийг өдөөж, Монгол

Зураг 9. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)



Улс энэ оны эхний хагас жилд 40.6 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 7 хувиар нэмэгдлээ. Төмөр замын тээвэр зохион байгуулалт сайжирч, дотоод үйлдвэрлэл нэмэгдсэнээр төмрийн хүдрийн экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар, дэлхийн зах зээл дэх алтны үнэ өссөнөөс шалтгаалан алтны экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 5 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 23 хувиар буурсан ба үүнд нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны эхний 6 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 57 хувиар, ноосны экспорт 45 хувиар, арьс ширний экспорт 31 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөллөө.

Монгол Улс 2024 оны эхний 6 сарын байдлаар импортоор 5.4 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 25.9 хувь буюу 1.1 тэрбум ам.доллаар өссөн үзүүлэлт боллоо.

Зураг 10. Импортын өөрчлөлт (сая ам.доллар)




Импортын өсөлтийн 10 хувийг үнийн өсөлт, 90 хувийг тоо хэмжээний өсөлт бүрдүүлж байна. Манай улс нь БНХАУ-аас нийт импортын бараа, бүтээгдэхүүний 36 хувийг худалдан авдаг ба тус улсын хэрэглээний үнийн өсөлт оны эхний хагас жилд 0 хувь байсан нь импортын үнийн өсөлт бага байхад нөлөөллөө. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт өсөлтийн 10.5 нэгж хувийг машин механик, тоног төхөөрөмж, 7.9 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 5.4 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

Дотоодын эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр сайжирснаар тоног төхөөрөмжийн импорт өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсөж 1.0 тэрбум ам.долларт хүрлээ. Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай зарим тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлснөөр тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг дэмжихээр байна. Мөн уул уурхай болон тээврийн салбарын идэвхжилтэй холбоотойгоор ачааны тээврийн хэрэгслийн импорт 337 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 51 хувиар, экскаватор, шанагат ачигчийн импорт 184 сая ам.долларт хүрч 2 дахин, дизелийн түлшний импорт 24 хувиар тус тус өслөө.

Өрхийн бодит орлого сүүлийн гурван улирал дараалан өсөж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар нэмэгдэж, 1.8 тэрбум ам.долларт хүрлээ.

Иргэдийн зээлийн өсөлт нь удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байдаг бөгөөд энэ оны эхний улиралд иргэдийн зээл 37.6 хувиар өссөн бол суудлын машины импорт 455 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 41 хувиар өссөн байна. Суудлын авто машины импорт өсөж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээтэй холбоотойгоор орон нутаг руу зорчих хөдөлгөөн нэмэгдсэнээр авто бензиний импорт 310 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46 хувиар өслөө.

Зураг 11. Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар)



1.2. Макро эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Эдийн засгийн өсөлтийг 2024 оны эцэст 5.6 хувь байхаар төсөөлж байна⁴. Салбаруудаар авч үзвэл, Оюутолгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өсөж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдан улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшиж, өсөлтийг хязгаарлахаар байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны жилийн эцэст 28.5 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Оюутолгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь нь газрын гүнд оршдог ба эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор 2024 онд зэсийн баяжмалын экспорт 1,560 мянган тоннд хүрч нэмэгдэхээр байна. Түүнчлэн, хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд нүүрсний экспорт 78 сая тоннд, төмрийн хүдрийн экспорт 8,400 мянган тоннд, газрын тосны экспорт 4,210 мянган баррельд тус тус хүрч, нийт экспортын дүн 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт тогтвортой байж, бизнесийн зээл олголт нэмэгдэж байгаагийн нөлөөгөөр уул уурхай, барилга, үйлдвэрлэлийн салбарын тоног төхөөрөмж, материалын импорт өсөхөөр байна. Мөн өрхийн орлого өсөж, хэрэглээний зээл олголт нэмэгдсэнээр хүнс, хэрэглээний бараа, шатахуун зэрэг бүтээгдэхүүний импорт өснө. Нийт импорт 2024 оны эцэст 11.8 тэрбум ам.долларт хүрч өсөх төлөвтэй байна.

Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспортын биет хэмжээний өсөлтийн нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 2024 онд ашигтай гарахаар хүлээгдэж байна.

Инфляц: Улсын жилийн инфляц 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшин болох 6 ± 2 хувийн дээд интервал орчимд байхаар хүлээгдэж байна. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 8.1 сая толгой мал хорогдсон нь махны нийлүүлэлт буурч, үнэ өсөх эрсдэлийг нэмэгдүүллээ. Мөн Тяньжин боомт дээрх чингэлгийн тоо хэвийн үеийнхээс давж 2024 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 5,800 орчим байгаа нь импортын барааны нийлүүлэлт тасалдаж, үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.


⁴ Эдийн засгийн өсөлтийн 2023 оны гүйцэтгэл 2024 оны 8 дугаар сард эцэслэгдэн зарлагдаж, 7.4 хувьд хүрсэнтэй холбоотойгоор эдийн засгийн 2024 оны өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс бага зэрэг буурууллаа.

Хоёр. Макро эдийн засгийн 2025 оны чиг хандлага, төсөөлөл

2.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд тохиосон цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, тэдгээрээс үүдэлтэй тээвэр, логистикийн саатал, үнийн өсөлт болон мөнгөний хатуу бодлогын нөлөө үргэлжилсэн ч ажил эрхлэлт, өрхийн орлогын өсөлт нийт эрэлтийг дэмжсэнээр дэлхийн эдийн засаг 2023 онд 3.3 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2 хувь, 2025 онд 3.3 хувь орчимд тогтвортой хадгалагдана гэж Олон улсын валютын сан (ОУВС) тооцоолж байна. Дэлхий нийтэд инфляцын түвшин аажмаар

Зураг 12. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁵ (хувь)



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, Блүүмберг терминал

буурах хандлага ажиглагдаж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг бий болгож, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал хурцдах, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй хэвээр байна.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг 2024 оны эхний хагас жилд 5.0 хувиар өслөө. Энэ оны эхний улирлын хувийн хэрэглээ болон экспортын гүйцэтгэл төсөөллөөс сайн байсантай холбоотойгоор ОУВС тус улсын эдийн засгийн өсөлтийн 2024 оны төсөөллийг 5.0 хувь, 2025 оны төсөөллийг 4.5 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус бүр 0.4 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч 2024 оны эхний хагас жилийн байдлаар үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт 10.1 хувиар, борлуулалт 25.0 хувиар тус тус буурч, салбарын уналт үргэлжилсэн хэвээр байгаа нь худалдааны эргэлт болон дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн эрэлт, үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Цаашид тус улс эдийн засгийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээний цар хүрээг хэрхэн тэлэх нь эдийн засгийн төлөвийг тодорхойлохоор байна.

ОХУ: ОХУ-ын эдийн засаг 2024 оны эхний улиралд 5.4 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд Украинд болж буй дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлт голлон нөлөөллөө. Цаашид дайнтай холбоотойгоор ОХУ-ын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. Тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2 хувь, 2025 онд 1.5 хувь орчимд байна гэж ОУВС тооцоолж байна.

АНУ: Хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 2.8 хувьд хүрч эрчимжлээ. 2022 оны 6

⁵ 2024 оны 8 дугаар сарын байдлаар


дугаар сард 9.1 хувьд хүрээд байсан инфляц 2024 оны 6 дугаар сард 3 хувь болж буурч, үнийн өсөлт саарах хандлага ажиглагдаж байгаа нь бодлогын хүү буурах хүлээлтийг нэмэгдүүлж байна. Тус улсын эдийн засаг 2024 онд 2.6 хувиар өсөх бол 2025 онд хөдөлмөрийн зах зээлийн халалт намжиж, хэрэглээний өсөлт саарах нөлөөгөөр эдийн засгийн өсөлт 1.9 хувьд хүрч саарна гэж ОУВС тооцоолж байна.

Евро бүс: Инфляцыг хязгаарлахаар хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа суларч, евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс доогуур буюу 0.4 хувь байлаа. Инфляцын дарамт буурсантай холбоотойгоор Европын төв банк бодлогын хүүг 2024 оны 6 дугаар сард 2019 оноос хойш анх удаа бууруулаад байна. Мөнгөний бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засаг 2024 онд 0.9 хувиар өсөх бол хэрэглээ болон хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр өсөлт 2025 онд 1.5 хувьд хүрч нэмэгдэнэ гэж ОУВС тооцоолж байна.


Түүхий эдийн зах зээлийн хандлага

Зэс: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 9,094 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өссөн байна. Дэлхийн томоохон зэсийн ил уурхайнуудын нэг болох “Кобре Панам” хаагдсан, “Англо Американ” компани зардлаа танаж, зэсийн үйлдвэрлэлээ бууруулахаа мэдэгдсэн нь богино хугацаанд нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөлж байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн эрэлт дунд хугацаанд нэмэгдэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2024 онд 9,500 ам.доллар, 2025 онд 10,000 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 13. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 14. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/трой унц)




Эх сурвалж: Блүүмберг терминал

Алт: Алтны 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 2,206 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өслөө. Геополитикийн хурцадмал байдал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь алтны эрэлт болон үнэ өсөхөд нөлөөлж байна. Дэлхийн банкны үзэж байгаагаар дунд хугацаанд дэлхийн эдийн засаг тогтворжиж, алтны эрэлт бага зэрэг сулрах хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2024 онд 2,200 ам.долларт, 2025 онд 1,850 ам.долларт хүрэхээр байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 118 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 15 хувиар буурсан байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа, Австрали улс шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил бүр 6 хувиар нэмэгдүүлэхээ зарласан нь үнэ буурахад голлон нөлөөллөө. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2024 онд 120 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 15. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 16. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)




Эх сурвалж: Блүүмберг терминал

Коксжих нүүрс: Сингапурын бирж дээрх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 278 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 19 хувиар буурсан байна. Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж, нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ коксжих нүүрсний татварыг сэргээсэн нь эрэлтийг бууруулахаар байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 250 ам.доллар, 2025 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

Газрын тос: Брент төрлийн газрын тосны 2024 оны эхний хагас жилийн дундаж үнэ 82 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 6 хувиар өслөө. ОПЕК-ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулахаар шийдвэрлэснээс гадна нефть, газрын тосны олборлолтын 35 орчим хувийг бүрдүүлдэг Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож, үнэ өсөж байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Энэтхэг улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 85 ам.доллар, 2025 онд 80 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 17. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



Эх сурвалж: Блүүмберг терминал

2.2. Макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Эдийн засгийн өсөлт 2025 онд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээ зэрэг салбаруудын өсөлттэй холбоотойгоор өмнөх оноос эрчимжиж, 8 орчим хувьд хүрэхээр төсөөлж байна. Тухайлбал, Оюутолгойн гүний уурхайгаас олборлох зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон баяжмал дахь зэс, алтны агуулга нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2025 оны эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлж, экспортын орлого нэмэгдэн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Уул уурхайн бус салбарын өсөлтийг 2025 онд 6.7 орчим хувь байхаар төсөөлж байна. Хөдөө аж ахуйн салбарт бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, өвөлжилт, хаваржилт хэвийн үргэлжлэх нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2025 онд мөн өсөхөөр байна. Түүнчлэн хувийн секторыг дэмжих замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлснээр иргэдийн цалингийн орлого сайжран эдийн засгийн дотоод идэвхжилийг хөшүүрэгдэж, худалдаа, үйлчилгээний борлуулалт хадгалагдан, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ болон салбаруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахаар зорьж байна. Тухайлбал, эрчим хүчний салбарт либералчлалыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлнэ. Салбаруудын үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт, технологийн дэвшил, инновацыг дэмжих, тоног төхөөрөмжийн татвар, тарифыг хөнгөлөх бодлого хэрэгжүүлж, хөдөө аж ахуй, боловсруулах, уул уурхай гэх мэт салбаруудад эерэг нөлөө үзүүлнэ. Мөн хөрш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийн гадаад эрэлтийг тэлснээр аж үйлдвэр, боловсруулах салбарыг дэмжинэ. Түүнчлэн, гадаад жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд худалдаа, үйлчилгээний салбар болон бусад салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлнө.

Гадаад худалдаа: Гадаад худалдаа эрчимжиж, 2025 онд нийт бараа эргэлт 32.8 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Оюутолгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэж, Тавантолгойн бүлэг ордын нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор нүүрсний экспортод эзлэх чанар сайтай баяжуулсан нүүрсний хэмжээ нэмэгдэхээр байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр нийт экспортын дүн 2025 онд 18.9 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэнэ. Мөн эдийн засгийг тэлэх томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, шинээр том төсөл эхлүүлснээр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өснө. Ингэснээр 2025 онд нийт импорт 13.9 тэрбум ам.долларт хүрч, 18 хувиар өсөхөөр төсөөлж байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтын

нэвтрүүлэх хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Экспортын орлого нэмэгдэж, гадаад өр төлбөрийн дарамт буурснаар 2025 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц үргэлжлэн нэмэгдэхээр байна.

Инфляц: Засгийн газраас төсвийн алдагдлыг хязгаарлан, төв банкнаас мөнгөний хатуу бодлого баримталж, инфляцыг бууруулах чиглэлд уялдаатай ажиллаж байна.

Дотоодын хүнсний инфляцыг бууруулах хүрээнд хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлөн, үйлдвэрлэл, технологийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дотоодын хүнсний нийлүүлэлт, худалдааны сүлжээг сайжруулах чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Мөн Засгийн газраас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнд экспортын орлого нэмэгдэж, гадаад валютын улсын нөөц нэмэгдсэнээр төгрөгийн ханш тогтвортой байхаар байна. Иймд импортын гаралтай инфляцын буурах хандлага хэвээр хадгалагдах төлөвтэй байна.

Түүнчлэн эрчим хүчний найдвартай байдал, хөрөнгө оруулалт ба үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд эрчим хүчний салбарын либералчлалыг эхлүүлэн, тарифын шинэчлэл хийж, бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. Эрчим хүчний тариф өсөх нөлөөгөөр 2025 онд инфляц бага зэрэг өсөж, суурь үеийн нөлөө 1 жил хадгалагдахаар байна.

Эдгээр бодлого, арга хэмжээний үр дүнд инфляц 2025 оны эцэст 6.0 хувь орчимд байхаар төсөөлж байна.

Гурав. Засгийн газраас 2025 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл

Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

Эдийн засгийг тогтворжуулах хүрээнд өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

Төсвийн бодлого: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Төсвийн бодлогын хүрээнд төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн мөчлөгийг сөрж, нийт эдийн засгийн идэвхилийн мөчлөгийг тогтворжуулах бодлогыг баримтална. Төсвийн сахилга батыг төрийн бүх шатанд сайжруулах, төсвийн зардлын үр ашиг болон бодлогын орон зайг нэмэгдүүлэхэд төрийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгоно. Төрийн худалдан авалтыг төлөвлөхдөө эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн, төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож хиймэл оюун ухааныг ашиглана.

Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах: Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсөв, мөнгөний уялдаатай бөгөөд оновчтой бодлого хэрэгжүүлэх, төв банк төсвийн шинжтэй арга хэмжээнээс бүрэн татгалзах шаардлагатай. Монголбанк гадаад валютын ханш зах зээлийн зарчмаар уян хатан тогтох нөхцөлийг бүрдүүлж, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулах нь зүйтэй. Дотоодын санхүүгийн зах зээлд гадаадын банк, хөрөнгө оруулагчдыг нэвтрүүлэх замаар салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.

Хоёр. Бизнес, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны орчин

Бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал, төрөөс бизнесийн салбарт хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, зах зээл дэх төрийн зохицуулалтыг багасгаж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ. Мөн төрөөс олгодог тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд шат дараатайгаар процессын менежмент хийх замаар иргэд, бизнес эрхлэгчдэд холбогдох төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, шуурхай хүргэхэд анхаарч, төрийн үйлчилгээнээс авах иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

Хөрөнгө оруулалтын хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа бусад багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаална.

Экспортын зах зээлийг өргөжүүлэх хүрээнд ОХУ-ын зах зээлд хөдөө аж ахуйн гаралтай 375 төрлийн барааг гаалийн татваргүй экспортлох боломжийг бүрдүүлэх Чөлөөт худалдааны түр хэлэлцээр, БНСУ-тай худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулна. Мөн БНХАУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээрийн албан ёсны хэлэлцээг эхлүүлнэ.

Импортын зардлыг бууруулах хүрээнд гаалийн баталгаат агуулахад олон улсын стандартыг нэвтрүүлж, мөрдүүлэх замаар цахим бүртгэлийн системээр бүх төрлийн үйл ажиллагааг автоматжуулж, хүний оролцоо, чирэгдлийг бууруулна.

Бизнесийн бүх төрлийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ хийлгэхийг шаардаж буй зохицуулалтыг оновчтой болгож хялбаршуулна. Энэ хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бизнес эрхлэхэд шаардлагатай үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулна. Бизнесийн үйл ажиллагаанд тавигдах стандартуудыг сайжруулж, зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд тус үнэлгээг хийж, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимаар шийдвэрлэдэг болно.

Гурав. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал

Уул уурхайн салбар: Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах томоохон орд газруудын тоог нэмэгдүүлэх хүрээнд геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, хайгуулын лицензийн тоог нэмэгдүүлэх, хайгуулын ажлын гүйцэтгэлийг сайжруулж, ордуудын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлнэ. Нарийвчилсан хайгуул хийх эрхийг хөрөнгө оруулагч нарт дуудлага худалдаагаар борлуулах тогтолцоонд шилжин ил тод байдлыг нэмэгдүүлнэ. Мөн уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог бэхжүүлэн өргөжүүлж, биржээр арилжсан бүтээгдэхүүнийг хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлнэ.

Боомтын шинэчлэл, тээвэр логистик: Хилийн боомтын дэд бүтцийг нэмэгдүүлэх хүрээнд хил дамнасан төмөр замуудын холболтыг эрчимжүүлж, боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, экспортыг нэмэгдүүлнэ. Мөн боомтуудыг иж бүрнээр өргөтгөх, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлнэ. Боомтуудад ухаалаг гарцыг бүрэн ашиглалтад оруулж, гаалийн бүрдүүлэлт, хяналтыг эрс хөнгөвчилж, боомтуудыг бүрэн цахимжуулна.

Эрчим хүчний салбарын либералчлал: Эрчим хүчний нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангаж, алдагдлын хэмжээг бууруулж, төрийн оролцоог багасгаж, бие даасан салбар болж төлөвших үйл явцыг дэмжинэ. Энэ хүрээнд 30 жил хүлээгдсэн эрчим хүчний либералчлалыг гүйцэтгэж, тарифыг нэмэгдүүлж, цахилгаан дулааны станцуудын өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ. Үр дүнд нь эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх мега төслүүдийг хэрэгжүүлнэ. Цаашид өрсөлдөх чадвар бүхий сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалтын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, эрчим хүч экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөдөө аж ахуйн салбар: Хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэлийн салбарын бодлогыг цогцоор нь шинэчилж, бие даасан хувийн хэвшлийн оролцогчид бүхий зах зээл болж төлөвших үйл явцыг дэмжинэ. Энэ хүрээнд төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгож буй бүх төрлийн үр ашиггүй татаасыг зогсоох, аливаа бүтээгдэхүүний (тухайлбал, мах) үнийг хязгаарлах зорилгоор нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд төрөөс оролцохгүй байх зэргээр зах зээл дэх төрийн оролцоог бууруулна. Мөн хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлж хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх, малыг вакцинжуулах үйл ажиллагааг үр

ашигтай зохион байгуулах, вакцинжуулалтын тогтолцоог сайжруулж малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, хөдөө аж ахуйг илүү бүтээмжтэй бизнесийн хэлбэрт шилжүүлэхэд оновчтой бодлого хэрэгжүүлнэ. Тухайлбал, тус салбарын үйлдвэрлэлд шинжлэх ухааны бүтээмж өндөртэй технологийг бодлогоор дэмжиж, хадлан, тэжээлийн тариалангийн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны зардлыг бууруулна. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гадаад худалдааг нээлттэй болгож, гадаад эрэлтийг нэмэгдүүлэх, угаасан ноолуурын экспортыг хориглосон техникийн зохицуулалтыг хугацаагүйгээр хүчингүй болгоно. Мөн бүх боомтоор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн (мах, махан бүтээгдэхүүн, байгалийн хадлан, тэжээл, бордоо) экспортлохыг зөвшөөрөх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрвөн улирлын аялал жуулчлал: Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг олон улсын стандартад нийцүүлж, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, "Go Mongolia" хөтөлбөрийг үргэлжлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. Гадаад жуулчдын Монгол Улсад аялах визний шаардлагыг хөнгөвчилж, түр чөлөөлсөн улсуудын визийг бүрэн чөлөөлнө. Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлнэ. Аялал жуулчлалын гол чиглэл, олон улсын авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, аялал жуулчлалын авто зам дагуух үйлчилгээний цогцолбор, амрах талбайг нэмэгдүүлнэ.

Боловсруулах салбар: Бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын түвшнийг шат ахиулах хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах ажлыг үргэлжлүүлнэ.

Харилцаа холбооны салбар: Үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлж эхэлнэ. Уг төслийг хэрэгжүүлснээр иргэд оршин суугаа газраасаа үл хамааран интернэттэй холбогдон, мэдээллийг тэгш хүртээмжтэй хүртэх, төрийн үйлчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ. Мөн сансрын холбооны бүх төрлийн үйлчилгээний хувьд гадаад улсын хиймэл дагуулын сүлжээнээс хамаарах хамаарлыг бууруулах боломж бүрдэнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болох боломжтой.

Барилга, худалдаа, үйлчилгээ, тээврийн салбар: Эдгээр салбарт цалинг цаг, долоо хоногоор тооцдог тогтолцоонд шилжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Дөрөв. Амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Нийтийн тээвэр, авто зам: Авто замын түгжрэлийг бууруулахад радио давтамжаар таних систем (RFID)-ийн хөгжүүлэлтийг дуусгаж, ашиглалтад оруулна. Мөн нийтийн тээврийн зорчих маршрутын зохион байгуулалтыг дэлхийн том хотуудын стандартын түвшинд сайжруулж, либералчлалыг үе шаттай хэрэгжүүлнэ. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хүрээнд метро барих ажлыг үргэлжлүүлнэ. Олон улсын чанартай хурдны замууд барих ажлыг эхлүүлнэ.

Агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт: Утаа багатай түлшний стандартыг тогтоон мөрдүүлж, зах зээлийг нь либералчилна. Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлуудыг эрчимжүүлж, гэр хорооллын дахин төлөвлөлтөд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Хүний хөгжлийн бодлого: Нийгмийн халамжийн бодлогыг оновчтой болгох хүрээнд зорилтот бүлгийг зөв тодорхойлж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ болон олгох хэлбэрт өөрчлөлт оруулан халамжийг эмзэг бүлгийн амьжиргааг хамгаалахад чиглүүлнэ.

Иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан тодорхой дүрмээр нэмэгдүүлнэ.

Их, дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагын багшийн ур чадварыг сайжруулж, сургалтын хөтөлбөр дэх англи хэлний агуулгыг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тус салбарын өрсөлдөөн, үйлчилгээний чанарыг сайжруулж, хэрэглэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээний олон сонголтуудыг бий болгоно. Цахимжилт, дижитал эрүүл мэндийн технологийг ашиглан алслагдсан бүс нутагт иргэн бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг санхүүгийн дарамтгүйгээр авах боломжийг бүрдүүлнэ. Мөн чанартай эмийн зах зээлийг бүрдүүлэх зорилгоор эмийн нийлүүлэлтийг эмийн хатуу зохицуулалттай орнуудын үйлдвэрлэгч нараас нэгдсэн байдлаар худалдан авалт хийх хэлцэл байгуулж, эмийг импортлоход хувийн хэвшлийн нээлттэй өрсөлдөөнийг дэмжинэ.

Дөрөв. Болзошгүй эрсдэлийн тойм

Нэг. Эрчим хүчний тасалдал: Манай улсын өнөөгийн эрчим хүчний хангамж, хүртээмж нь өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангаж чадахааргүй нөхцөл байдалтай байна. Эрчим хүчний үнэ нь үйлдвэрлэлийн бодит өртгөөс доогуур байгаа нь үр ашгийг бууруулж, эрчим хүчний салбар алдагдалтай ажиллаж байна. Үүний зэрэгцээ манай улсын эрчим хүчний хангамж нь нэг төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, дамжуулалт, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн буюу эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэлтэй нөхцөл байдалд байна. Эрчим хүчний нийлүүлэлт тасалдах нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

Хоёр. Зуд, ган, мал, амьтны өвчин: Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурах, үүнийг даган малчин, тариаланч аж ахуйн нэгж, өрхүүдийн орлого, хэрэглээ хумигдах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ өсөх, малын халдварт өвчин тархах эрсдэл өндөр байна. Тухайлбал, 2023 онд улсын хэмжээнд 4.9 сая мал хорогдож, төл бойжилт өмнөх оноос 28 хувиар буурсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт нутгийн 80 хувийг хамарсан зудын улмаас улсын хэмжээнд 8.1 сая толгой мал хорогдож, бойжуулсан төлийн тоо өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар буураад байна. Хоёр жил дараалсан өвөлжилт, хаваржилтын хүндрэл, зудын улмаас ирэх онуудад махны нийлүүлэлт буурч, хүнсний инфляц нэмэгдэх, мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл багасаж, малчдын амьжиргаа дордон хэрэглээ хумигдах, цаашлаад эдийн засаг дахь хөрөнгийн хуримтлалд сөрөг нөлөө үзүүлж, өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.

Гурав. Экспортын түүхий эдийн үнийн бууралт: Экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн бууралт манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг хязгаарлах эрсдэлтэй байна.

Дөрөв. Геополитикийн тогтворгүй байдал: ОХУ-Украины нөхцөл байдал даамжрах, Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, Улаан тэнгист халдлага үргэлжлэх зэрэг эрсдэлүүд авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж болзошгүй байна.

Тав. Нийлүүлэлтийн тасалдал: Монгол Улсын нийт импортын 80 орчим хувь нь Тяньжин боомтоор дамжин, төмөр замаар тээвэрлэгдэн Замын-Үүд боомтоор орж ирдэг. КОВИД-19 цар тахлын үед Тяньжин боомтод 9,000 гаруй чингэлэг бөөгнөрч, импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдал үүссэнээс шалтгаалан инфляц 16.9 хувьд хүрсний 8.9 нэгж хувь буюу 55 гаруй хувийг импортын инфляц бүрдүүлж байв. Тяньжин боомтоос өдөрт гарах галт тэрэгний тоо буурсантай холбоотойгоор энгийн үед 3,000 орчим байдаг тус боомт дээрх чингэлгийн тоо 2024 оны 7 дугаар сарын байдлаар 5,800 даваад байгаа нь нийлүүлэлтийн хугацааг уртасгаж, бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.

ТАВ. Монгол улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл

Хүснэгт 2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.5	5.0	4.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	33,864.7	35,253.2	37,749.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.6	33.7	32.3
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	35,795.2	37,347.3	40,084.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.7	35.7	34.3
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,930.5	-2,094.1	-2,335.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,955.2	33,159.0	35,414.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.6	31.7	30.3
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	1,909.5	2,094.1	2,335.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, дээд түвшнээр /тэрбум төгрөг/	52,255.5	52,352.9	52,547.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.0	50.0	45.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,572.3	2,850.4	2,931.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.7	2.7	2.5

ЗУРГАА. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр төсвийн зарим тусгай шаардлагуудад өөрчилсөнтэй холбоотойгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг дээрх хуулийн өөрчлөлт, төсвийн тусгай шаардлагуудад нийцүүлэн боловсрууллаа.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцлоо. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 129 ам.доллар байна.

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дэх хэсэгт нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэж заасан. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2025 онд 2.0 хувь, 2026 онд 2.0 хувь, 2027 онд 2.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.1. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2025	2026	2027
Хуулийн хязгаар	2.0	2.0	2.0
Төсөөлөл	2.0	2.0	2.0

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2025 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025-аас 2027 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 3.3. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

	2025	2026	2027
Хуулийн хязгаар	60.0	60.0	60.0
Төсөөлөл	55.0	50.0	45.0

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.5	5.0	4.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	33,864.7	35,253.2	37,749.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.6	33.7	32.3
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	35,795.2	37,347.3	40,084.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.7	35.7	34.3
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,930.5	-2,094.1	-2,335.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,955.2	33,159.0	35,414.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.6	31.7	30.3
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	1,909.5	2,094.1	2,335.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, дээд түвшнээр /тэрбум төгрөг/	52,255.5	52,352.9	52,547.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.0	50.0	45.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,572.3	2,850.4	2,931.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.7	2.7	2.5

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн барихтай холбоотой Эдийн засаг, хөгжлийн яамнаас оролцох ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Утас
1	Л.Гантөмөр	Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	99115948
2	О.Мягмардорж	Эдийн засаг, хөгжлийн яамны Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга	88886106

---oOo---